**Төвийн эрхэм зорилго:**
Цэргийн урлагийн онол, хөгжлийн чиг хандлага, Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн асуудлуудыг  судалж, үндэсний цэргийн урлагийг хөгжүүлэх.




**Үйл ажиллагааны зорилго:**
Цэргийн урлагийн онол, хөгжлийн чиг хандлагыг судалж, үндэсний цэргийн урлагийг хөгжүүлэх, Зэвсэгт хүчний байгуулалтыг төгөлдөржүүлэхэд чиглэсэн суурь судалгаа явуулж, онол, аргазүйн үндэслэлтэй санал, зөвлөмж боловсруулах.

**Үйл ажиллагааны гол зорилт:**

- Цэргийн урлагийн онол, хөгжлийн чиг хандлагыг судалж, үндэсний цэргийн урлагийг

хогжvvлэх онол, арга зvйг боловсруулах;
- Зэвсэгт хvчний байгуулалтыг тоголдоржvvлэх онол, арга зvйн судалгаа явуулж, санал, зовломж боловсруулах;
- Цэргийн удирдлага, Зэвсэгт хvчний бэлэн байдлыг дээшлvvлэх сургалтын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн онол, практикийн судалгаа явуулах;
- Энхийг дэмжих ажиллагааны туршлага, сургамжид судалгаа явуулах.

**Тvvхэн замнал:**
Цэргийн урлаг судлалын товийн тvvхэн замнал нь Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хvрээлэнгийн vvсэл, хогжил тvvхтэй салшгvй холбоотой богоод 1979 оны 08 дугаар сарын 03-ны одрийн БХЯ-ны сайдын тушаалаар батлагдсан бvтцийн дагуу байгуулагдсан “Цэрэг, техникийн сектор”-ыг овлон залгамжилж, судалгааны хэд хэдэн товийг салбарлан торvvлсэн ууган тов юм.
Тvvнээс хойш орон тоо, бvтэц зохион байгуулалтын оорчлолтийн дагуу 1991 онд “Цэргийн онол, урлагийн сектор”, 1993 онд “Цэргийн урлаг, онолын сектор”, 1996 онд “Зэвсэгт хvчний байгуулалтын судалгааны тов”, 1999 онд “Цэргийн онол, стратеги, судалгааны тов”, 2001 онд “Цэргийн урлаг, онолын судалгааны тов”, 2010 онд “Дайн, цэргийн урлаг судлалын тов“, 2016 оноос **“Цэргийн урлаг судлалын төв“** нэртэйгээр vйл ажиллагаагаа явуулж байна.